



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

“Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон захирал Б.Гүрсоронзон байгуулсан 2024 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзонтой Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3. “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2024 оны онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн захирал Б.Гүрсоронзонд хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4. Захирал Б.Гүрсоронзонд хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээр гаргахыг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Р.Баасандоржид зөвшөөрсүгэй.


5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн  
182 дугаар тогтоолын хавсралт

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛД  
2024 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

| д/д | Хуулийн этгээдийн нэр               | Захирлын нэр  | Цэвэр ашиг<br>/мян.төг/ | Цэвэр ашгийн дүнгээс<br>хасаж тооцох валютын<br>ханшийн өөрчлөлтөөс<br>олсон ашиг алдагдал<br>/мян.төг/ | Урамшуулал<br>тооцох цэвэр<br>ашиг /мян.төг/ | Олгох урамшууллын<br>хэмжээ /мян.төг/ |
|-----|-------------------------------------|---------------|-------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------|---------------------------------------|
| 1   | "Автотээврийн үндэсний<br>төв" ТӨҮГ | Б.Гүрсоронзон | 11,301,108.50           | 0.0                                                                                                     | 11,301,108.50                                | 27,260.22                             |

(хорин долоон сая,  
хоёр зуун жаран  
мянга, хоёр зуун  
хорин төгрөг)